



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ  
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.04.18 № 341

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Аймгийн 2024 оны төсвийн нийт орлого 79,682.3 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 76,355.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпорац ААТҮГ-т олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс нийт 5,608.5 сая төгрөгийн, Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т олгосон нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс нийт 799.2 сая төгрөгийн, Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлээс нийт 472.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, харьяа байгууллагуудад 7,564.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос нийт 2,452.4 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан, харьяа байгууллагуудын аудитаар 167.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,354.3 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд 153.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 16.9 сая төгрөгийн 3 заалт зөвлөмж хүргүүлсэн зэрэг үндэслэлээр "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн болно.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хариуцлага тооцох, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулан, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тусгай сангуудын зээлийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах, батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг тухай бүр олгож, хяналтыг сайжруулах, орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, тооцоо судалгаатай боловсруулж батлуулах, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг тусган батлуулах талаар 7 зөвлөмж бүхий аудитын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

- Хавсралт:
1. Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан <sup>26</sup> хуудастай.
  2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан <sup>29</sup> хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



8225020424

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ  
ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ 2024 ᠣᠨᠢ ᠨᠢᠭᠳᠰᠢᠨ  
ᠲᠥᠰᠪᠢᠶᠢᠨ ᠭᠤᠢᠴᠡᠲᠭᠡᠯᠳᠤ ᠬᠢᠶᠰᠢᠨ  
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ

**АЙМГИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН**

2025 он

| Тайлан бэлтгэсэн:  | АГУУЛГА   |    |
|--|---|----|
| Дарга, Тэргүүлэх аудитор<br>Г.Гүнжидмаа  | <b>ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b> .....   | 3  |
|  | <b>ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ</b> .....  | 4  |
|  | <b>I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ,<br/>ГҮЙЦЭТГЭЛ</b> .....                 | 5  |
| Аудитын менежер:<br>Д.Эрдэнэчимэг  | 1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт .....  | 5  |
|  | 1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл.....   | 5  |
|  | <b>II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ,<br/>ГҮЙЦЭТГЭЛ</b> .....               | 8  |
| Ахлах аудитор:<br>Д.Цэрэнханд<br>М.Атарцэцэг   | 2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт .....   | 8  |
|  | 2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл .....   | 9  |
|  | 2.2.2 Засаг даргын нөөц хөрөнгө .....   | 13 |
|  | 2.2.3 Орон нутгийн хөгжлийн сан.....  | 13 |
| Аудитор:<br>Н.Гэрэлмаа<br>Э.Сүнжидмаа  | 2.2.4 Хоршоо хөгжүүлэх сан .....  | 14 |
|  | <b>III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН<br/>НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ</b> ..... | 15 |
|  | 4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....   | 15 |
|  | 4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....   | 16 |
|  | 4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээн дэх нийцлийн аудитын<br>асуудал:.....                    | 16 |
| 2025 оны 04 дүгээр сар   | <b>IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....   | 17 |
| Уг тайланг Говь-Алтай аймаг<br>дахь Төрийн аудитын газрын<br>цахим хуудаснаас үзнэ үү:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> | <b>V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН<br/>САНАЛ, ДҮГНЭЛТ</b> .....             | 18 |
|  | 5.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар:.....  | 20 |
|  | <b>VI АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....   | 20 |
|  | <b>6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:</b> .....   | 21 |
| Аудитын тайлантай<br>холбоотой асуудлаар нэмж<br>тодруулах, асууж лавлах<br>зүйл байвал дараах утсаар<br>харилцана уу.                   |   |    |
| Аудитын тайлантай<br>холбоотой асуудлаар нэмж<br>тодруулах, асууж лавлах<br>зүйл байвал 70483413<br>дугаар утсаар харилцана<br>уу        |   |    |
| ХАЯГ:<br>Говь-Алтай аймаг<br>Есөнбулаг сум<br>Жинст баг<br>Хөгжил хороолол 1402  |   |    |

**Товчилсон үгийн жагсаалт**

|    |        |  |
|----|--------|--|
| 1  | ААН    | Аж ахуйн нэгж                                    |
| 2  | ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар            |
| 3  | ААТҮГ  | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                |
| 4  | АДБОУБ | Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага |
| 5  | АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт    |
| 6  | БОАЖГ  | Байгаль орчин, аялал жуулчлалын газар            |
| 7  | ЗГНХ   | Засгийн газрын нөөц хөрөнгө                      |
| 8  | ЗДТГ   | Засаг даргын Тамгын газар                        |
| 9  | ЗДНХ   | Засаг даргын нөөц хөрөнгө                        |
| 10 | ИТХ    | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                     |
| 11 | ОНХС   | Орон нутгийн хөгжлийн сан                        |
| 12 | ӨЭМТ   | Өрхийн эрүүл мэндийн төв                         |
| 13 | ТЕЗ    | Төсвийн ерөнхийлөн захирагч                      |
| 14 | ТТЗ    | Төсвийн төвлөрүүлэн захирагч                     |
| 15 | УИХ    | Улсын Их Хурал                                   |
| 16 | УТҮГ   | Улсын төсөвт үйлдвэрийн газар                    |
| 17 | ХХС    | Хоршоо хөгжүүлэх сан                             |

**Хүснэгтийн тайлбар**

|            |  |
|------------|--|
| Хүснэгт 1  | Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын төлөвлөлт  |
| Хүснэгт 2  | Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэл  |
| Хүснэгт 3  | Орон нутгийн 2024 оны нийт орлого /сумдаар/  |
| Хүснэгт 4  | Тусламж санхүүжилтийн орлого   |
| Хүснэгт 5  | Орон нутгийн 2024 оны төсвийн зардал, нийт тэнцэл  |
| Хүснэгт 6  | Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн                                     |
| Хүснэгт 7  | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт |
| Хүснэгт 8  | Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /сумдаар/                           |
| Хүснэгт 9  | Төсвөөс сумдын 100 жилийн ойд олгосон хөрөнгийн зарцуулалт                                 |
| Хүснэгт 10 | Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалт  |
| Хүснэгт 11 | ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл   |
| Хүснэгт 12 | Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл   |
| Хүснэгт 13 | Аймгийн 2024 оны төсвийн тодотгол  |
| Хүснэгт 14 | Төсвийн төсөлд өгсөн санал, хэрэгжилт  |
| Хүснэгт 15 | Төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан  |

**Дүрслэлийн тайлбар**

|           |   |
|-----------|---|
| Дүрслэл 1 | Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа /5 жил |
|-----------|---|

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>1</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4<sup>2</sup> дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

### Аудитын зорилт

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

### Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Орон нутгийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан
- Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- Төсвийн тодотгол, төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон бусад холбогдох хэлтэс, сумдын төсөвт байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд, М.Атарцэцэг, аудитор Н.Гэрэлмаа, Э.Сүнжидмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

<sup>1</sup> 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

<sup>2</sup> 8.9.4. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангуулахаар ажилласан байна.

Төрийн аудитын газраас Говь-Алтай аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан татварын болон татварын бус орлогыг 1,404.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 1,445.1 сая төгрөгөөр бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх 9, нийт 2,850.0 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 26,065.0 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийг 17,357.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Говь-Алтай аймгийн 2024 оны татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос бүрдэх эх үүсвэрийг нийт 95,867.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 76,355.0 сая төгрөг зарцуулжээ.

Тайлант оны төсвийн орлогын гүйцэтгэл 84.3 хувь, зарлагын гүйцэтгэл 84.9 хувьтай байна. Аймгийн 2024 оны төсвийн саналыг онлайнд суурилсан FISCAL-B системээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн 45, төсөл сан 58, төрийн сангийн нэгж 21, орон нутгийн өмчит 13, хяналтад байгаа 15, орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт авч байгаа 99, нийт 251 нэгжийн тайланг хамруулсан байна.

Тайлант онд аймгийн төсөвт 2 удаа тодотгол хийсэн бөгөөд анх орлого, зарлагыг 22,088.9 сая төгрөгөөр баталж, сүүлийн тодотголоор 18,575.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ****1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт**

Аймгийн 2024 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журам, аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрхзүйн актуудыг үндэслэн төлөвлөж, төсвийн төслийн саналыг FISCAL-B системд оруулснаар Сангийн яам хянаж, баталгаажуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны Төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн орон нутгийн төсвийн суурь орлогыг 11,567.3 сая төгрөгөөр тооцож төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Тайлант 2024 онд төсвийг 2 удаа тодотгон баталсан бөгөөд сүүлийн тодотгосон төсвөөр аймгийн төсвийн орлогыг 17,396.5 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогыг 23,267.6 сая төгрөгөөр, нийт 40,664.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын төлөвлөлт

| № | Үзүүлэлт                          | Төсвийн төсөл | Сангийн яамны хянасан дүн | 2024 он      |            |            | /сая төгрөг/<br>Анх баталсан дүнгээс өссөн/буурсан |
|---|-----------------------------------|---------------|---------------------------|--------------|------------|------------|--|
|   |                                   |               |                           | Анх баталсан | Тодотгол 1 | Тодотгол 2 |  |
| 1 | Орон нутгийн төсвийн суурь орлого | 11,567.3      | 13,565.0                  | 22,088.9     | 39,560.1   | 40,664.1   | 18,575.2   |

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024 оны тогтоол, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл

Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг 40,664.1 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 15,987.7 сая төгрөгөөр, төсвийн төслөөс 29,096.8 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан суурь орлогоос 27,099.1 сая төгрөгөөр, анх баталсан төсвөөс 18,575.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг нэр төрлөөр бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- Сангийн яамнаас хянаж ирүүлсэн ААНОАТ-ыг аймгийн ИТХ-ын тогтоолоор 12,799.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан;
- Аймгийн төсвийн орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 1,392.2 сая төгрөгийн, бусад орлого 334.2 сая төгрөгийн, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэхтэй холбоотой 64.0 сая төгрөгийн, газрын төлбөрийн 80.3 сая төгрөгийн орлогыг тус тус төлөвлөөгүй, хүүгийн орлогыг 418.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр орлого төвлөрөөгүй;
- Сумдын шууд бус орлого, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 704.0 сая төгрөгөөр давсан нь үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

**1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл**

Орон нутгийн төсвийн орлогыг 40,664.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 92.7 хувиар буюу 5,370.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 22,877.7 сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 93.2 хувийг татварын, 6.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.

## Хүснэгт 2. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт                             | 2023 он         |                 | 2024 он         |              |                |
|--------------------------------------|-----------------|-----------------|-----------------|--------------|----------------|
|                                      | Гүйцэтгэл       | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь         | Зөрүү          |
| <b>Нийт орлого ба тусламжийн дүн</b> | <b>21,755.1</b> | <b>40,664.1</b> | <b>35,294.1</b> | <b>86.8</b>  | <b>5,370.0</b> |
| <b>Татварын орлого</b>               | <b>16,662.0</b> | <b>38,470.0</b> | <b>32,928.7</b> | <b>85.6</b>  | <b>5,541.4</b> |
| Орлогын албан татвар                 | 12,115.3        | 33,251.5        | 26,784.8        | 80.6         | 6,466.7        |
| Хөрөнгийн албан татвар               | 2,520.8         | 1,911.0         | 3,493.6         | 182.8        | (1,582.6)      |
| Бусад татвар төлбөр хураамж          | 2,025.9         | 3,307.5         | 2,650.3         | 80.1         | 657.3          |
| <b>Татварын бус орлого</b>           | <b>5,093.1</b>  | <b>2,194.1</b>  | <b>2,365.4</b>  | <b>684.8</b> | <b>(171.4)</b> |
| Нийтлэг бус татварын орлого          | 3,419.8         | 2,144.1         | 2,071.3         | 96.6         | 72.8           |
| Хөрөнгийн орлого                     | 1,673.3         | 50.0            | 294.1           | 588.3        | (244.1)        |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 5,370.0 сая төгрөгөөр тасарсан нь ААНОАТ-ын орлого 8,522.5 сая төгрөгөөр тасарч голлон нөлөөлсөн байна.

**Давсан орлогын шалтгаан тайлбар:**

- Хувь хүний орлогын албан татварын орлого 2,035.0 сая төгрөгөөр давсан нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасан, мөн “Хан-Алтай Ресурс” ХХК нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг аймагт төвлөрүүлдэг болсон, Төрийн сангийн удирдлагын цахим системийг 2023 оны 1 дүгээр сараас бүрэн нэвтрүүлж эхэлсэн бөгөөд худалдаа, үйлчилгээ, хувиараа бизнэс эрхлэгч иргэдийн татварын цахим системд үүсгэсэн төлбөрийн нэхэмжлэхэд үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэж байгаа, Монгол банкны бодлогын хүүгийн түвшинтэй уялдан арилжааны банкны хадгаламжийн хүү өссөн, шинээр ашиглалтад орсон нийтийн орон сууцыг худалдан борлуулсны татварыг төвлөрүүлсэн, иргэдэд олгосон хувьцааны ногдол ашиг, малчдад олгосон арьс ширний урамшуулал, хонь, тэмээний ноосны урамшууллын татвар сумдын төсвийн орлогод төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан;
- Хөрөнгийн албан татвар 1,582.6 сая төгрөгөөр давсан нь 2022 онд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор эмийн сан болон шатахуун түгээх станцуудын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ нэмэгдсэн. Мөн “Алтайн хүдэр” ХХК болон “Хан-Алтай ресурс” ХХК-иас өмнөх онуудын өр болох нийт 243.2 сая төгрөгийг төсөвт нөхөн төвлөрүүлсэн;
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 143.7 сая төгрөгөөр давсан нь 2022 онд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ нэмэгдсэн;
- Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр 33.9 сая төгрөгөөр давсан нь шинээр 500 хоршоо байгуулагдсантай холбоотойгоор улсын тэмдэгтийн хураамж нэмэгдсэн;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 22.6 сая төгрөгөөр давсан нь “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ нь цахим систем ашиглан Есөнбулаг сумын айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг авдаг болсон;
- Галт зэвсэгийн улсын үзлэг тооллогоор Татварын газар болон Цагдаагийн газар галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээллийг тулган баталгаажуулж тоо мэдээлэлд хяналт тавин ажилласнаар бууны албан татвар 15.9 сая төгрөгөөр давсан;

**Тасарсан орлогын шалтгаан тайлбар:**

- ААНОАТ-ын орлого 8,522.5 сая төгрөгөөр тасарсан нь үндэслэлгүй төлөвлөснөөс;

- Дуудлага худалдааны орлого 461.2 сая төгрөгөөр тасарсан нь сумын Засаг дарга дуудлага худалдаа явуулах захирамж, шийдвэр гараагүйгээс;
- Хүүгийн орлого 418.2 сая төгрөгөөр тасарсан нь УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтийг төсөвт төлөвлөөгүй бөгөөд төсвийн жилд шүүхийн шийдвэр гарсан 2 иргэний материалыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлж зээлийг төсөвт төвлөрүүлсэн. Бусад зээлдэгч нарын зээлийг төлүүлэх арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлж байгаа бөгөөд уг зээлийн төлөлттэй холбоотой;
- Малын тоо толгойн албан татвар 175.0 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөсөн орлого ороогүйтэйгээс;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 156.0 сая төгрөгөөр тасарсан нь зарим уул уурхайн компани үйл ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалан төлөвлөсөн төсвийн орлогууд тасарсан;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрын орлого 61.9 сая төгрөгөөр тасарсан нь Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамнаас тусгай зориулалтын ан агнуурын зөвшөөрөл олгоогүй;
- Газрын төлбөрийн орлого 33.6 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн газрын төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн Чандмань сумын урд онуудын газрын төлбөрийн өрийг 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөөнд төлөвлөсөнтэй холбоотойгоор орлого тасарсан;
- Түрээсийн төлбөрийн орлогыг Аймгийн ИТХ-ын 2023 оны 56 дугаар тогтоолын дагуу түрээсийн гэрээг Орон нутгийн өмчийн газраар батлуулан нийт төвлөрөх түрээсийн орлогын 40 хувийг аймгийн төсвийн орлогод, 60.0 хувийг тухайн байгууллагын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Түрээслүүлэгч байгууллага аймгийн төсөвт төвлөрөх орлогыг төвлөрүүлээгүйтэй холбоотойгоор түрээсийн орлого 17.9 сая төгрөгөөр тасарсан;
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.1 сая төгрөгөөр тасарсан нь ААН-үүд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй учир уг төлбөрийг төлдөггүй;
- Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөрын орлого 0.2 сая төгрөгөөр тасарсан нь чонон хармаг болон байгалийн ямар нэгэн ургамлыг түүж ашиглаж байх явцад хяналт шалгалт хийн уг нэр төрлийн орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй бол иргэд сайн дураар төлбөр төлөөгүй байна.

Орон нутгийн нийт орлого 5,370.0 сая төгрөгөөр тасарсан нь аймаг 7,312.6 сая төгрөгөөр, Чандмань сум 93.0 сая төгрөгөөр, Дарив сум 59.5 сая төгрөгөөр төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 3. Орон нутгийн 2024 оны нийт орлого /сумдаар/ /сая төгрөг/

| Сум,<br>байгууллага | Орлого  |         |       |         | Сум,<br>байгууллага | Орлого          |                 |             |                |
|---------------------|---------|---------|-------|---------|---------------------|-----------------|-----------------|-------------|----------------|
|                     | Төл     | Гүйц    | Хувь  | Зөрүү   |                     | Төл             | Гүйц            | Хувь        | Зөрүү          |
| Алтай               | 1,033.7 | 1,156.9 | 111.9 | (123.2) | Хөхморьт            | 475.3           | 612.8           | 128.9       | (137.5)        |
| Баян-Уул            | 509.7   | 630.7   | 123.7 | (121.0) | Цогт                | 654.7           | 687.0           | 104.9       | (32.3)         |
| Бигэр               | 442.5   | 542.2   | 122.5 | (99.6)  | Цээл                | 767.4           | 1,073.4         | 139.9       | (306.0)        |
| Бугат               | 444.5   | 563.2   | 126.7 | (118.7) | Чандмань            | 693.1           | 600.1           | 86.6        | 93.0           |
| Дарив               | 467.0   | 407.4   | 87.3  | 59.5    | Шарга               | 342.5           | 358.6           | 104.7       | (16.1)         |
| Дэлгэр              | 342.8   | 467.4   | 136.4 | (124.7) | Эрдэнэ              | 422.7           | 532.1           | 125.9       | (109.4)        |
| Жаргалан            | 262.8   | 360.2   | 137.1 | (97.4)  | Гуулин тосгон       | 151.1           | 184.9           | 122.3       | (33.7)         |
| Тайшир              | 328.1   | 345.9   | 105.4 | (17.8)  | Баянтоорой тосгон   | 198.6           | 255.5           | 128.7       | (56.9)         |
| Тонхил              | 455.2   | 493.1   | 108.3 | (37.9)  | Есөнбулаг           | 14,393.4        | 14,987.3        | 104.1       | (593.9)        |
| Төгрөг              | 456.0   | 510.8   | 112.0 | (54.8)  | Аймаг               | 17,396.5        | 10,083.9        | 58.0        | 7,312.6        |
| Халиун              | 426.6   | 440.7   | 103.3 | (14.1)  |                     |                 |                 |             |                |
| <b>Нийт дүн</b>     |         |         |       |         |                     | <b>40,664.1</b> | <b>35,294.1</b> | <b>86.8</b> | <b>5,370.0</b> |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Илрүүлэлт:

- Төлөвлөлтийг бодитой тооцоогүйгээс аймгийн орон нутгийн 4 нэр төрлийн татварын орлого 9,565.3 сая төгрөгөөр, түрээсийн орлого 18.0 сая төгрөгөөр, нийт 9,583.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн байгууллагын өөрийн орлогыг 968.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,260.1 сая төгрөг буюу 291.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.

**Илрүүлэлт:**

- Орлогын төлөвлөгөө нэр төрлөөр 10,292.3 сая төгрөгөөр тасарсан. (Аймгийн ТЕЗ-9,583.3 сая төгрөг, Чандмань сум-210.2 сая төгрөг, Дарив сум-116.1 сая төгрөг, Тонхил сум-82.0 сая төгрөг, Халиун сум-47.1 сая төгрөг, Эрдэнэ сум-45.0 сая төгрөг, Төгрөг сум-42.9 сая төгрөг, Дэлгэр сум-31.0 сая төгрөг, Цогт сум-30.0 сая төгрөг, Есөнбулаг сум-28.1 сая төгрөг, Тайшир сум-19.6 сая төгрөг, Бигэр сум-11.5 сая төгрөг, Алтай сум-9.2 сая төгрөг, Бугат-7.5 сая төгрөг, Гуулин тосгон-4.9 сая төгрөг, Жаргалан сум-3.7 сая төгрөг, Цээл сум-2.3 сая төгрөг, Баян-Уул сум-1.0 сая төгрөг, Хөхморьт сум 0.5 сая төгрөгөөр)
- Санхүүгийн дэмжлэг 7,564.8 сая төгрөгөөр дутуу олгосон.(Сумдад 2,620.7 сая төгрөг, аймгийн төсвийн байгууллагуудад 4,944.1 сая төгрөгөөр)
- Татварын орлого болон ХХС-гийн орлогыг бодитой төлөвлөөгүй 573.5 сая төгрөг байна. (сумдын ЗДТГ-86.9 сая төгрөг, Тонхил, Халиун, Дарив, Эрдэнэ, Есөнбулаг сумдын ХХС-гийн орлого 469.1 сая төгрөгийг төлөвлөөгүй)
- Малын тоо толгойн албан татварын орлого 13.2 сая төгрөгийг ОНХС-гийн дансанд дутуу төвлөрүүлсэн. (Тонхил сум-5.0 сая төгрөг, Баян-Уул сум-4.5 сая төгрөг, Дэлгэр сум-3.5 сая төгрөг, Шарга сум-0.1 сая төгрөг)
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 12.2 сая төгрөгийг санхүүжилтийг дутуу авсан. (Марал-Алтай ӨЭМТ-10.5 сая, Энх-Алтай ӨЭМТ-0.8 сая төгрөг, Жаргалан-Алтай ӨЭМТ-0.9 сая төгрөг)
- ОНХС-ийн орлогыг зөрүүтэй тооцсон, дутуу төвлөрүүлсэн, зөрүүтэй баталсан, түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй зэрэг 295.3 сая төгрөг байна. (Дэлгэр сум-237.3 сая төгрөг, Бугат сум-50.0 сая төгрөг, Шарга сум-2.8 сая төгрөг, Алтай сум-1.9 сая төгрөг, Цээл сум-1.8 сая төгрөг, Чандмань-1.0 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар-0.5 сая төгрөгөөр)

Хүснэгт 4. Тусламж санхүүжилтийн орлого

| Үзүүлэлт                 | 2023 он         |                 | 2024 он         |              |              |
|--------------------------|-----------------|-----------------|-----------------|--------------|--------------|
|                          | Гүйцэтгэл       | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь         | Зөрүү        |
| ОНХС-ийн нэгдсэн сангаас | 14,863.7        | 17,357.3        | 16,596.2        | 95.6         | 761.1        |
| Тусламж/ Шилжүүлэг       | 18,458.8        | 26,065.0        | 26,065.0        | 100.0        | 0.0          |
| <b>дүн</b>               | <b>33,322.5</b> | <b>43,422.3</b> | <b>42,661.2</b> | <b>195.6</b> | <b>761.1</b> |

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Говь-Алтай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 26,065.0 сая төгрөг, ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 17,357.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авах дэмжлэгийг бүрэн, ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 761.2 сая төгрөгөөр дутуу авсан байна.

**II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт**

Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагын дүнг 36,619.5 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймгийн ИТХ-аас анх 70,383.1 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн төсөвт нийт 2 удаагийн тодотголыг хийж, аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зардлыг 115,959.6 сая төгрөг буюу 45,576.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт 5. Орон нутгийн 2024 оны төсвийн зардал, нийт тэнцэл

| Үзүүлэлт            | Төсвийн төсөл     | Сангийн яамны хянасан дүн | 2024 он           |                   |                   | /сая төгрөг/<br>Анх баталсан дүнгээс өссөн/буурсан |
|---------------------|-------------------|---------------------------|-------------------|-------------------|-------------------|--|
|                     |                   |                           | Анх баталсан      | Тодотгол 1        | Тодотгол 2        |  |
| Орон нутгийн орлого | 11,567.3          | 13,565.0                  | 22,088.9          | 39,560.1          | 40,664.1          | (18,575.2)   |
| Нийт зарлага        | 58,456.2          | 36,619.5                  | 96,874.3          | 115,959.6         | 115,959.6         | (19,085.3)   |
| <b>ЗӨРҮҮ</b>        | <b>(46,838.9)</b> | <b>(23,054.4)</b>         | <b>(74,785.3)</b> | <b>(76,399.5)</b> | <b>(75,295.5)</b> | <b>510.2</b>                                       |

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024 оны тогтоол, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл

Орон нутгийн төсвийн орлогыг 18,575.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбоотой нийт зарлагыг анх баталснаас 19,085.3 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 76,355.0 сая төгрөг буюу 79.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн

| Үзүүлэлт                                      | 2023 он   |           | 2024 он   |      |          |
|---|-----------|-----------|-----------|------|----------|
|   | гүйцэтгэл | Төлөвлөлт | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү    |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн             | 56,171.5  | 95,867.2  | 76,355.0  | 79.6 | 19,512.2 |
| А. Урсгал зардал                              | 37,710.1  | 66,170.8  | 55,024.6  | 83.2 | 11,146.2 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал               | 36,532.1  | 59,308.6  | 52,924.5  | 89.2 | 6,384.1  |
| Урсгал шилжүүлэг                              | 1,178.0   | 1,871.2   | 1,720.4   | 91.9 | 150.8    |
| Б. Хөрөнгийн зардал                           | 17,360.9  | 28,001.9  | 20,976.7  | 74.9 | 7,025.2  |
| В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 1,100.5   | 1,694.5   | 353.7     | 20.9 | 1,340.8  |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 72.0 хувийг урсгал зардал, 27.4 хувийг хөрөнгийн зардал, 0.04 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 746.8 сая төгрөгөөр буурч, хөрөнгийн зардал өмнөх оноос 3,615.8 сая төгрөгөөр, урсгал зардал 17,314.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт зардал 35.9 хувиар өссөн байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, сумдын 100 жилийн ойтой холбоотой бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжсэнтэй холбоотой байна.

Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтнуудад 31.7 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

Хүснэгт 7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт /сая төгрөг/

| №  | Хөтөлбөр   | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү   | Хувь |
|----|--|------------------|-----------|---------|------|
| 1  | 70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | 4,331.6          | 4,166.9   | 164.7   | 96.2 |
| 2  | 70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага                | 47,321.8         | 37,702.7  | 9,619.0 | 79.7 |
| 3  | 70417 Мэргэжлийн хяналт  | 347.9            | 320.3     | 27.6    | 92.1 |
| 4  | 70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх                           | 416.6            | 416.2     | 0.4     | 99.9 |
| 5  | 70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт                     | 21,270.6         | 15,597.9  | 5,672.7 | 73.3 |
| 6  | 70801 Мал аж ахуйг хөгжүүлэх                                     | 50.0             | 4.4       | 45.6    | 8.8  |
| 7  | 70802 Газар тариалан хөгжүүлэх                                   | 50.0             | 0.0       | 50.0    | 0.0  |
| 8  | 71403 Ойжуулалт  | 228.2            | 226.5     | 1.7     | 99.3 |
| 9  | 71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага                      | 1,833.3          | 1,665.9   | 167.4   | 90.9 |
| 10 | 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ                                | 2,986.5          | 2,442.8   | 543.7   | 81.8 |
| 11 | 71701 Биеийн тамир спорт   | 471.4            | 368.2     | 103.2   | 78.1 |
| 12 | 71702 Соёл урлаг   | 2,623.7          | 2,081.5   | 542.2   | 79.3 |
| 13 | 71801 Сургуулийн өмнөх боловсрол                                 | 2,419.6          | 2,248.7   | 170.9   | 92.9 |

|    |       |   |                 |                 |                 |             |
|----|-------|---|-----------------|-----------------|-----------------|-------------|
| 14 | 71802 | Ерөнхий боловсрол                       | 8,227.2         | 7,824.2         | 403.0           | 95.1        |
| 15 | 71804 | Мэргэжлийн боловсрол                    | 889.2           | 662.4           | 226.8           | 74.5        |
| 16 | 71806 | Насан туршийн болон албан бус боловсрол | 22.2            | 18.4            | 3.8             | 82.8        |
| 17 | 71902 | Нийгмийн халамж                         | 130.0           | 123.0           | 7.0             | 94.6        |
| 18 | 72101 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих         | 2,247.6         | 485.1           | 1,762.5         | 21.6        |
|    |       | <b>Дүн</b>                              | <b>95,867.2</b> | <b>76,355.1</b> | <b>19,512.2</b> | <b>79.6</b> |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 18 хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч мал аж ахуй, газар тариалан хөгжүүлэх сангуудын эх үүсвэр бүрдээгүй, ААНБ-аас шалгуур хангасан төсөл ирүүлээгүйгээс Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас тус тус зээл олгоогүй байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /сумдаар/ /сая төгрөг/

| Сум,<br>байгууллага | Зарлага    |                 |       |         | Сум,<br>байгууллага | Зарлага         |                 |             |                |
|---------------------|------------|-----------------|-------|---------|---------------------|-----------------|-----------------|-------------|----------------|
|                     | Төлөвлөгөө | Гүйцэтгэл       | Хувь  | Зөрүү   |                     | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь        | Зөрүү          |
| Алтай               | 2,969.0    | 1,875.8         | 63.2  | 1,093.2 | Хөхморьт            | 2,240.6         | 1,971.1         | 88.0        | 269.5          |
| Баян-Уул            | 3,045.1    | 2,744.8         | 90.1  | 300.3   | Цогт                | 2,721.3         | 2,346.0         | 86.2        | 375.4          |
| Бигэр               | 2,154.2    | 1,838.3         | 85.3  | 315.9   | Цээл                | 2,241.7         | 1,994.4         | 89.0        | 247.3          |
| Бугат               | 2,305.9    | 1,850.2         | 80.2  | 455.6   | Чандмань            | 2,563.8         | 2,200.1         | 85.8        | 363.7          |
| Дарви               | 1,653.2    | 1,386.5         | 83.9  | 266.7   | Шарга               | 2,031.1         | 1,708.8         | 84.1        | 322.4          |
| Дэлгэр              | 2,233.0    | 2,031.1         | 91.0  | 201.9   | Эрдэнэ              | 2,957.9         | 2,693.9         | 91.1        | 264.0          |
| Жаргалан            | 1,987.3    | 1,624.6         | 81.7  | 362.7   | Гуулин тосгон       | 370.5           | 360.0           | 97.2        | 10.5           |
| Тайшир              | 1,962.4    | 1,665.4         | 84.9  | 297.0   | Баянтоорой тосгон   | 701.6           | 692.6           | 98.7        | 9.1            |
| Тонхил              | 2,478.0    | 2,043.6         | 82.5  | 434.3   | Есөнбулаг           | 17,544.9        | 12,385.8        | 70.6        | 5,159.1        |
| Төгрөг              | 2,372.1    | 1,982.7         | 83.6  | 389.4   | Аймгийн шууд        | 37,066.1        | 29,118.2        | 78.6        | 7,947.8        |
| Халиун              | 2,267.6    | 1,841.1         | 81.19 | 426.6   |                     |                 |                 |             |                |
|                     |            | <b>Нийт дүн</b> |       |         |                     | <b>95,867.2</b> | <b>76,355.0</b> | <b>79.6</b> | <b>7,311.4</b> |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн нийт зарлагын 38.1 хувь буюу 29,118.2 сая төгрөгийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, 61.9 хувь буюу 47,236.8 сая төгрөгийг сумдын байгууллагууд эзэлж байна.

**Илрүүлэлт:**

- Худалдан авах ажиллагаа зарлаагүй 595.5 сая төгрөг байна.(аймгийн ЗДТГ-213.7 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-183.5 сая төгрөг, “Солонго дулаан” ААТҮГ-52.6 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ 53.6 сая төгрөг, Бугат сумын ЗДТГ-36.6 сая төгрөг, Марал-Алтай ӨЭМТ 34.1 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-21.4 сая төгрөгөөр)
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч, зөвлөх ажиллуулан цалин олгож, 87.3 сая төгрөгийг зарцуулсан. (Аймгийн ЗДТГ-62.5 сая, Цогт сумын ЗДТГ-24.8 сая төгрөг)
- Цалин, хөлс нэмэгдэл урамшуулалтай холбоотой илүү дутуу олгосон, тушаал шийдвэргүй, үндэслэлгүй урамшуулал олгосон, амралт цалин давхардуулсан, зэрэг 441.8 сая төгрөг (АХТҮГ-176.9 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-59.1 сая төгрөг, Солонго дулааны станц ААТҮГ-30.5 сая төгрөг, Марал-Алтай ӨЭМТ-4.8 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-4.0 сая төгрөг)
- Төсвийг зориулалт бусаар 103.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, сургалтын боршур, хөгжмийн түрээс, спортын хувцас хэрэгсэл худалдан авч үр ашиггүй зарцуулсан. (Инноваци бизнес сургалт хөгжлийн төв-56.3 сая төгрөг, аймгийн ЗДТГ-33.8 сая, аймгийн ИТХ-12.9 сая төгрөг /
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 85.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн. (Аймгийн ЗДТГ-23.4 сая төгрөг, сумдын ИТХ, ЗДТГ-62.1 сая төгрөг)

- Цалингийн нөхөн олговорт 31.9 сая төгрөг олгож, төсвийг хохироосон. (Тайшир сумын ЗДТГ-19.3 сая төгрөг, АХТҮГ-8.4 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-4.2 сая төгрөг)

**2.2.1 Засаг дарга ерөнхий дансны талаар:**

Аймгийн төсвийн нийт урсгал зардлын 31.8 хувь буюу 9,215.5 сая төгрөгийг Засаг дарга Ерөнхий данснаас зарцуулсан байна.

Төсвийн тухай хууль тогтоомжид Засаг дарга ерөнхий дансны талаар тусгагдаагүй бөгөөд аймгийн ИТХ-аас Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, бусад зардлыг санхүүжүүлэхээр баталдаг байна.



Говь-Алтай аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 онд боловсруулан, аймгийн Засаг даргын 2021 оны А/606 захирамжаар баталсан байна. Уг бодлогын баримт бичгийн 4.5-д тусгай сангуудын бүртгэл, тайлагнал хэсэгт "төсвийн аль нэг төвлөрүүлэн эсвэл шууд захирагчид хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнүүдийг холбогдох дүрэм, журамд тусдаа данстай байхаар заагаагүй бол ИТХ-аар Засаг дарга дансанд нэгтгэн батална" гэж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4<sup>3</sup>, 18 дугаар зүйлийн 18.4<sup>4</sup> дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Дүрслэл 1: Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа /5 жил/



Засаг дарга ерөнхий дансны санхүүжилт жилээс жилд нэмэгдэж, 2020 онд 380.5 сая төгрөг, 2021 онд 602.5 сая төгрөг, 2022 онд 1,169.5 сая төгрөг, 2023 онд 2,706.0 сая төгрөг байсан бол 2024 онд өмнөх оноос 3.5 дахин нэмэгдэж 9,215.0 сая төгрөг болжээ.

Засаг дарга ерөнхий данс /100050051000/-аас 2024 онд 3,438.4 сая төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд шагнал урамшуулал, 1,400.0 сая төгрөгийг сумдын ой тэмдэглэхэд, 1,942.6 сая төгрөгийг бусад хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр

хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсээр байна.

<sup>3</sup> Төсвийн ерөнхий данс" гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нээгдэн бүртгэх харилцах дансыг;  
<sup>4</sup> Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна.

**Илрүүлэлт:**

- Засаг дарга Ерөнхий данснаас 3,664.4 сая төгрөгийг ТХТХ зөрчин боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт болон буцалтгүй тусламж дэмжлэгээр олгосон;
- Анхан шатны нотлох баримтгүй ерөнхий данснаас 254.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Төсвөөс 26.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон;
- Тушаал шийдвэр захирамжгүйгээр 10.0 сая төгрөгийг Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв ОНӨААТҮГ-т шилжүүлсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 4 байгууллагад 176.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон;
- Сумдын ой тэмдэглэхэд 1,400.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

**Хүснэгт 9. Төсвөөс сумдын 100 жилийн ойд олгосон хөрөнгийн зарцуулалт /сая төгрөг/**

| Сумын нэрс  | Нийт зардал    | Үндсэн хөрөнгө бэлтгэхэд | Бараа материал   |               |            | ТХТХууль зөрчин үр ашиггүй зардалд зарцуулсан |   |                         |
|-------------|----------------|--------------------------|------------------|---------------|------------|---|---|-------------------------|
|             |                |                          | Хангамж материал | Урсгал засвар | Шатахуун   | Хоол, хүнс айраг                              | Шагнал, хүлээн авалт, медаль, өргөмжлөл, хэвлэл, түрээс | Нийт зардалд эзлэх хувь |
| 1 Алтай     | 99.1           | -                        | 1.9              | -             | -          | 50.2  | 47.0  | 98.1                    |
| 2 Баян-Уул  | 50.0           | -                        | -                | -             | -          | -   | 50.0  | 100.0                   |
| 3 Бигэр     | 88.8           | -                        | 36.6             | 22.7          | -          | 24.5  | 5.0   | 33.2                    |
| 4 Дэлгэр    | 98.2           | 1.3                      | 5.7              | 6.9           | -          | 48.1  | 36.1  | 85.7                    |
| 5 Жаргалан  | 55.0           | 20.0                     | 20.0             | 15.0          | -          | -   | -   | -                       |
| 6 Тайшир    | 99.6           | 11.0                     | 8.6              | 75.7          | -          | -   | 4.2   | 4.2                     |
| 7 Тонхил    | 97.4           | -                        | 3.9              | 48.5          | 6.3        | 8.9   | 29.8  | 39.7                    |
| 8 Төгрөг    | 97.9           | -                        | -                | -             | -          | 20.5  | 77.5  | 100.0                   |
| 9 Хөхморьт  | 96.5           | 85.3                     | 11.1             | -             | -          | -   | -   | -                       |
| 10 Цогт     | 100.0          | -                        | 50.0             | -             | -          | -   | 50.0  | 50.0                    |
| 11 Цээл     | 99.9           | 14.5                     | -                | 9.5           | -          | 20.0  | 55.9  | 76.0                    |
| 12 Чандмань | 100.0          | -                        | -                | 7.7           | -          | 13.3  | 79.1  | 92.4                    |
| 13 Шарга    | 99.8           | 99.8                     | -                | -             | -          | -   | -   | -                       |
| 14 Эрдэнэ   | 99.3           | -                        | 21.3             | 19.6          | -          | 48.3  | 10.1  | 58.8                    |
| <b>Дүн</b>  | <b>1,281.6</b> | <b>232.0</b>             | <b>159.2</b>     | <b>205.8</b>  | <b>6.3</b> | <b>233.7</b>                                  | <b>459.3</b>  | <b>54.1</b>             |

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 100 жилийн ойтой 16 сумд 1,600.0 сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Засаг дарга ерөнхий данснаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр 1,400.0 сая төгрөгийг 14 сумд олгосон бөгөөд Бугат, Дарив сумд 200.0 сая төгрөгийг олгоогүй байна. Сумууд гүйцэтгэлээр 1,281.6 сая төгрөгийг зарцуулж, 118.3 сая төгрөгийг татан төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор хөрөнгийн зарцуулалтыг тодорхой тусгаж өгөөгүйгээс сум бүр харилцан адилгүй арга хэмжээнд зарцуулсан байна.

*Тухайлбал: Шарга сум 99.8 сая төгрөгөөр Наадмын талбайн засвар хийсэн бол Баян-Уул, Дэлгэр, Төгрөг, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ сумууд хоол хүнс, айраг, ажлын хөлс, бэлэг дурсгал, шагнал, хүлээн авалт зэрэг үр ашиггүй арга хэмжээнд зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1<sup>5</sup> дэх заалтыг зөрчсөн байна.*

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд хийсэн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Ерөнхий данс”-ны зориулалт арга хэмжээ, хууль эрх зүйг тодорхой болгох талаар Үндэсний аудитын газарт санал хүргүүлсэн байна.

**Илрүүлэлт:**

5 Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хорилоно:

- Сумын 100 жилийн ойн санхүүжилтээс 21.9 сая төгрөгөөр хамаарал бүхий этгээдээс худалдан авалт хийсэн. (Бигэр сумын ЗДТГ)
- Сумын 100 жилийн ойтой холбоотой 693.0 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

### 2.2.2 Засаг даргын нөөц хөрөнгө

Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтцэд орон нутгийн нөөц хөрөнгө буюу Засаг даргын нөөц хөрөнгө 1 хөтөлбөр, арга хэмжээ болон хэрэгжиж байна. Тайлант 2024 онд 2,471.7 сая төгрөгийг зарцуулахаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 2,109.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалт /сая төгрөг/

| №  | Сумдын нэр | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Үүнээс: ТХТХ зөрчсөн |
|----|------------|----------------|----------------|----------------------|
| 1  | Алтай      | 57.6           | 51.8           | 31.2                 |
| 2  | Баян-Уул   | 15.0           | 13.3           | 3.5                  |
| 3  | Бигэр      | 15.0           | 13.7           | 6.4                  |
| 4  | Бугат      | 20.0           | 17.7           | 3.7                  |
| 5  | Дарви      | 25.0           | 19.3           | 9.5                  |
| 6  | Дэлгэр     | 22.8           | 14.3           | 9.5                  |
| 7  | Жаргалан   | 47.2           | 46.8           | 4.3                  |
| 8  | Тайшир     | 45.0           | 45.0           | 31.7                 |
| 9  | Тонхил     | 70.0           | 42.3           | 8.5                  |
| 10 | Төгрөг     | 27.5           | 14.3           | 8.9                  |
| 11 | Халиун     | 68.0           | 68.0           | 14.0                 |
| 12 | Хөхморьт   | 20.0           | 18.6           | 17.4                 |
| 13 | Цогт       | 278.0          | 262.7          | 170.5                |
| 14 | Цээл       | 61.3           | 61.2           | 16.7                 |
| 15 | Чандмань   | 26.0           | 25.9           | 3.7                  |
| 16 | Шарга      | 38.5           | 36.8           | 31.9                 |
| 17 | Эрдэнэ     | 60.0           | 55.5           | 42.7                 |
| 18 | Есөнбулаг  | 209.0          | 208.9          | 105.3                |
| 19 | Аймаг      | 1,365.8        | 1,093.4        | 91.7                 |
|    | <b>Дүн</b> | <b>2,471.7</b> | <b>2,109.4</b> | <b>611.2</b>         |

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аймаг, сумдын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 611.2 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлсэн байна. Тухайлбал: Цогт сум бусад сумтай харьцуулахад хамгийн өндөр буюу 170.5 сая төгрөгийг бэлэг дурсгал, 100 жилийн ойн концерт, буцалтгүй тусламж, дэмжлэг зэрэгт зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тогтоолоор тус сумд Засаг дарга ерөнхий данснаас 75.0 сая төгрөгийг олгохоор давуу байдал үүсгэж баталсан байна.

Илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөөс 519.5 сая төгрөгийн бэлэг, бусад зардлыг олгосон.
- Аймгийн ЗДТГ нь 91.7 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бэлэг дурсгалын зүйл, контент, мэдээ бэлтгэх болон бусад арга хэмжээнд нотлох баримтгүйгээр зориулалт бусаар зарцуулсан.

### 2.2.3 Орон нутгийн хөгжлийн сан

ОНХС-гийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 17,357.4 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 16,596.2 сая төгрөгийг санхүүжүүлж, 761.2 сая төгрөгийг дутуу олгожээ. Нийт санхүүжилтээс сумдад 9,889.5 сая төгрөг буюу 56.9 хувийг олгосон байна.

Хүснэгт 11. ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

| Сумын нэр | ОНХС-ийн орлого |           |       | Сумын нэр | ОНХС-ийн орлого |           |       |
|-----------|-----------------|-----------|-------|-----------|-----------------|-----------|-------|
|           | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл | Зөрүү |           | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл | Зөрүү |
| Алтай     | 883.8           | 834.9     | 48.9  | Хөхморьт  | 289.7           | 277.0     | 12.7  |
| Баян-Уул  | 380.4           | 363.6     | 16.7  | Цогт      | 548.9           | 524.7     | 24.2  |
| Бигэр     | 589.2           | 563.3     | 25.9  | Цээл      | 500.5           | 478.5     | 22.0  |
| Бугат     | 310.1           | 296.5     | 13.6  | Чандмань  | 242.8           | 232.1     | 10.7  |
| Дарви     | 169.1           | 161.7     | 7.4   | Шарга     | 324.6           | 320.3     | 4.3   |
| Дэлгэр    | 489.6           | 468.1     | 21.5  | Эрдэнэ    | 878.3           | 839.7     | 38.6  |
| Жаргала   | 179.0           | 171.1     | 7.9   | Есөнбулаг | 2,462.3         | 2,354.0   | 108.3 |
| Н         |                 |           |       |           |                 |           |       |

|                 |       |       |      |       |                 |                 |              |
|-----------------|-------|-------|------|-------|-----------------|-----------------|--------------|
| Тайшир          | 441.4 | 422.0 | 19.4 | Аймаг | 7,468.0         | 7,141.9         | 326.1        |
| Тонхил          | 499.4 | 477.5 | 22.0 |       |                 |                 |              |
| Төгрөг          | 440.3 | 420.9 | 19.4 |       |                 |                 |              |
| Халиун          | 260.0 | 248.6 | 11.4 |       |                 |                 |              |
| <b>Нийт дүн</b> |       |       |      |       | <b>17,357.4</b> | <b>16,596.2</b> | <b>761.2</b> |

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ОНХС-аас нийт 7,468.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,141.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Нийгмийн салбарын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 1,600.0 сая төгрөг, "150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төрийн захиргааны, бусад төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 500.0 сая төгрөг нийт 2,100.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөж баталж санхүүжүүлсэн байна.

Энэ нь тус сангийн хөрөнгийн 35.5 хувийг хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд төлөвлөж, зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3<sup>6</sup>, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.6<sup>7</sup> дахь заалтыг зөрчсөн байна. Уг асуудлыг шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторт санал уламжлав.

Илрүүлэлт:

- Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 2,100.0 сая төгрөгийг буцалтгүй тусламж дэмжлэг хэлбэрээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар анхан шатны нотлох баримтгүйгээр бусдад олгосон байна.
- Цогт сумын ОНХС-гаас 197.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан.

## 2.2.4 Хоршоо хөгжүүлэх сан

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2023 онд 961.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,005.5 сая төгрөгийн зээл төлөгдөж байсан бол 2024 онд 621.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,065.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус сангийн орлогын төлөвлөлтийг сумд үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Тухайлбал: Тонхил, Халиун сумууд огт төлөвлөөгүй, Дарив, Эрдэнэ, Есөнбулаг сумууд 0.8-1.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19-282 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. Иймд төсвийн төслийг хянаж үзэхдээ тусгай сангуудын орлогын тооцооллыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөж байгааг харгалзан үзэх шаардлагатай байна.

Хүснэгт 12. Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

| Сумын нэр       | ХХС-ийн орлого |           |        | Сумын нэр | ХХС-ийн орлого |                |              |
|-----------------|----------------|-----------|--------|-----------|----------------|----------------|--------------|
|                 | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл | Хувь   |           | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Хувь         |
| Алтай           | 33.5           | 55.0      | 164.0  | Хөхморьт  | 32.0           | 43.6           | 136.0        |
| Баян-Уул        | 40.0           | 31.9      | 80.0   | Цогт      | 27.0           | 56.0           | 207.0        |
| Бигэр           | 45.4           | 38.4      | 85.0   | Цээл      | 35.0           | 24.6           | 70.0         |
| Бугат           | 15.0           | 12.8      | 85.0   | Чандмань  | 67.8           | 48.6           | 72.0         |
| Дарви           | 0.8            | 51.6      | 6450.0 | Шарга     | 89.0           | 45.5           | 51.0         |
| Дэлгэр          | 37.0           | 65.3      | 176.0  | Эрдэнэ    | 1.7            | 33.9           | 1994.0       |
| Жаргалан        | 63.7           | 61.3      | 96.0   | Есөнбулаг | 1.0            | 282.1          | 28210.0      |
| Тайшир          | 64.2           | 57.8      | 90.0   |           |                |                |              |
| Тонхил          | 0.0            | 21.0      | -      |           |                |                |              |
| Төгрөг          | 68.0           | 55.1      | 81.0   |           |                |                |              |
| Халиун          | 0.0            | 80.5      | -      |           |                |                |              |
| <b>Нийт дүн</b> |                |           |        |           | <b>621.1</b>   | <b>1,065.0</b> | <b>171.5</b> |

<sup>6</sup> хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

<sup>7</sup> "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 187.4 сая төгрөгийн үндсэн зээл, 4.5 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөөгүйд төлбөрийн акт тогтоож, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч арга хэмжээ авч ажиллаагүй 17.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Нийт 187.4 сая төгрөгийн үндсэн зээлийг төлөөгүй. (Цогт сум-54.0 сая, Баян-Уул сум-23.5 сая, Дэлгэр сум-19.4 сая, Хөхморьт сум-18.5 сая төгрөг, Халиун сум-15.6 сая төгрөг, Шарга сум-11.8 сая төгрөг, Цээл сум-10.4 сая төгрөг, Төгрөг сум-6.7 сая төгрөг, Тонхил сум-6.3 сая төгрөг, Чандмань сум-6.1 сая төгрөг, Алтай сум-5.8 сая төгрөг, Бигэр сум-3.2 сая төгрөг, Есөнбулаг сум-3.6 сая төгрөг, Дарив сум-1.4 сая төгрөг, Бугат сум-0.9 сая төгрөг);
- Нийт 4.5 сая төгрөгийн зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй. (Цогт сум-2.3 сая төгрөг, Халиун сум-0.7 сая төгрөг, Хөхморьт сум-0.4 сая төгрөг, Баян-Уул сум-0.4 сая, Дэлгэр сум-0.3 сая, Тонхил сум-0.2 сая, Төгрөг сум-0.1 сая, Шарга сум-0.03 сая төгрөг);
- Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө тасарсан 33.5 сая төгрөг байна. (Чандмань сум-19.6 сая төгрөг, Бугат сум-7.3 сая төгрөг, Бигэр сум-0.7 сая төгрөг)
- Хоршоо хөгжүүлэх сангаас 1.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. (Чандмань сум-0.9 сая төгрөг, Алтай сум-0.8 сая төгрөг)
- Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлийг төлүүлэх талаар хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, арга хэмжээ аваагүй 26.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй. (Цогт сум-14.7 сая төгрөг, Шарга сум-9.6 сая төгрөг, Тонхил сум-2.4 сая төгрөг)
- Хоршоо хөгжүүлэх сангаас Дэлгэр сум 6 иргэнд 51.0 сая төгрөгийн зээл олгосон.
- Халиун сумын хоршоо хөгжүүлэх сангийн 36.3 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй байна.
- Шарга сум хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр, зарцуулалт 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй баталсан.

### III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 32,386.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 715.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,671.9 сая төгрөгийн зөрчилд албан албан шаардлага, 23,898.9 сая төгрөгийн зөвлөмж, 2,100.0 сая төгрөгийн 2 асуудлыг шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудитор санал уламжлав.

#### 4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Говь-алтай аймгийн Засаг даргын шилэн дансны цахим системд таван саяаас дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлэх цэс байхгүй бөгөөд өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 636.1 сая төгрөгийн 58 захирамж, тушаалыг мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 85.5 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, дутуу хөтөлсөн 13 байгууллага /Аймгийн ЗДТГ, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Есөнбулаг сумдын ЗДТГ, Тонхил, Төгрөг, Шарга сумын ТТЗ, Халиун сумын СХС, Есөнбулаг сумын ИТХ, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ/.

## 4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас төр, бүх шатны байгууллага, нийтийн алба тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж байгаа тул Засаг даргын нөөц хөрөнгө, сумдын 100 жилийн ойтой холбоотой зөрчилтэй асуудлыг нэгтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 1,257.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 45.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,211.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 22.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг баталсан. Уг журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6 заалтуудын дагуу аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгөөс 607.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

## 4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд дэх нийцлийн аудитын асуудал:

Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, байгууллагын дотоод журамтай нийцэж байгаа эсэх асуудлыг энэ хүрээнд хамруулсан.

### Илрүүлэлт

- Орон нутгийн өмчит хуулийн этгээд 1,120.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. (АХТҮГ-1,021.5 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээ ТҮГ-96.6 сая төгрөг, Инноваци бизнес хөгжлийн төв-2.2 сая төгрөг)
- Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөсөн зардлыг 72.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. (Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-68.5 сая төгрөг, Инноваци бизнес хөгжлийн төв УТҮГ-4.4 сая төгрөг)
- Төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг хуваан босго үнээс доогуур дүнгээр хэсэгчлэн баталж, 230.7 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. (Цээл сумын ОНХС-98.9 сая төгрөг, Бигэр сум-79.6 сая төгрөг, Халиун сум-28.1 сая төгрөг, Аймгийн засаг дарга ерөнхий данс-24.0 сая төгрөг)
- Урьдчилгаа санхүүжилт 17.5 сая төгрөгийг гэрээний дагуу олгосон ч ажлыг эхлээгүй. (Баянтоорой тосгоны Захирагчийн алба)
- Сумын ИТХ-аар батлаагүй 15.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн. (Баян-Уул сумын ОНХС-11.1 сая төгрөг, Есөнбулаг сумын ОНХС-4.6 сая төгрөг)
- Хөрөнгийг зах зээлийн ханшаас 2.4 сая төгрөгөөр илүү өндөр үнээр бэлтгэсэн. (Есөнбулаг сумын ИТХ-2.4 сая төгрөг)
- Есөнбулаг сумын ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн данснаас 39.7 сая төгрөгөөр айл өрхийн халаалтын шугамын дэмжлэг олгосон.
- Шарга сумын ОНХС хэрэгжүүлсэн 99.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй
- Сумдын ОНХС 215.2 сая төгрөгийн гэрээний хугацаа дууссан байхад ажлыг хүлээн аваагүй. (Цогт сумын ОНХС-193.8 сая төгрөг, Тонхил сумын ЗДТГ-9.8 сая төгрөг, Мал хамгаалах сан-5.5 сая төгрөг, Халиун сумын ОНХС-5.0 сая төгрөг, Нийтийн номын сан-1.1 сая төгрөг)

#### IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсвийн дансаар 4,054.1 сая төгрөг төвлөрсөн нь өмнөх оноос 14.3 буюу 581.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт нэмэлт төсвийн 90.2 хувь буюу 3,660.6 сая төгрөгийг аймгийн Засаг даргаас хуваарилсан, 9.8 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах орлогоос бүрджээ.

- Дээд шатны төсөв захирагчдаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө-3,321.4 сая төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж-261.3 сая төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого- 86.9 сая төгрөг;
- ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 339.2 сая төгрөг байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан боловч нэмэлт орлогын дансаар 2024 онд 86.9 сая төгрөг төвлөрч зарцуулсан.

Нэмэлт орлогыг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Нэмэлт төсвийг зарцуулахдаа цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 21.0 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 20.8 сая төгрөг;
- Хангамж бараа материалын зардалд 125.6 сая төгрөг;
- Норматив зардалд 4.3 сая төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардал 114.8 сая төгрөг;
- Томилолтын зардалд 7.9 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,202.1 сая төгрөг;
- Бараа үйлчилгээний бусад зардалд 1,926.4 сая төгрөг;
- Хөрөнгийн зардалд 143.0 сая төгрөг;

Нийт нэмэлт төсвийн 47.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 29.6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд зарцуулсан нь төсвийн дотоод хяналтыг сулруулах, төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

Нэмэлт төсөв өмнөх оноос 14.3 хувь буюу 581.9 сая төгрөгөөр өсөж, төсвийн гүйцэтгэлийн 5.2 хувийг эзэлж байна. Нэмэлт төсөв жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь төсвийн зардал тэлэх, хяналтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

##### Илрүүлэлт

- Цогт сумын ЗДТГ: Аймгийн Засаг даргын Тамгын газраас өр барагдуулах зорилгоор 75.0 сая төгрөгийн олгосон боловч, 24.0 сая төгрөгөөр компьютер худалдан авч, 23.4 сая төгрөгийг үйл ажиллагаандаа, 7.6 сая төгрөгөөр өр барагдуулахад зарцуулсан.
- Говь-Алтай аймгийн ЗДТГ: Нэгдсэн үндэсний байгууллагаас Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон нийт санхүүжилт 145.2 сая төгрөгийн 69 хувь буюу 100.3 сая төгрөгийг шууд зардалд тайлагнаж, 9.0 сая төгрөгийг зориулалт бусаар Жангар арга хэмжээнд зарцуулж, 37.5 сая төгрөгийг өөрийн болон хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулсан.
- Нэмэлт санхүүжилтийн данснаас 60.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан. (Нийтлэг үйлчилгээ ААТҮГ нь 50.0 сая төгрөг, Инноваци бизнес хөгжлийн төв-10.3 сая төгрөг),
- Нэмэлт санхүүжилтийн зардлаас 6.0 сая төгрөгийг зориулалт бус өөр зардалд зарцуулсан. (Тайшийр сумын ЗДТГ-5.4 сая, Тонхил сумын ЗДТГ-0.6 сая төгрөг)

## V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

### 5.1 Аймгийн төсвийн тодотгол

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор нийт эх үүсвэрийг 58,600.3 сая төгрөгөөр баталсан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Говь-Алтай аймагт олгох татаас санхүүжилтийг 26,064.8 сая төгрөгөөр баталснаар улсын төсвөөс авах татаас санхүүжилтийг 7,607.2 сая төгрөгөөр бууруулсан ба ОНХС-гийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 764.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргаас төсвийн тодотголыг өргөн барихдаа улсын төсвийн тодотголтой уялдуулан, зардлыг бууруулахгүйгээр ААНОАТ-ыг 7,679.1 сая төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 631.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д өргөн барьсан нь бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

Гэвч аймгийн ИТХ-ын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор Засаг даргаас өргөн барьсан төсвийн ААНОАТ-ыг 5,120.0 сая төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 1,000.0 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 560.0 сая төгрөг, нийт 6,680.0 сая төгрөгийн эх үүсвэрийг үндэслээгүй нэмж баталсан байна.

Нэмсэн эх үүсвэрийг Засаг дарга ерөнхий дансанд 5,679.5 сая төгрөг, аймгийн ЗДТГ-т 1,089.6 сая төгрөг, аймгийн ИТХ-д 175.0 сая төгрөг, БОАЖГ-т 138.3 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилж, баталсан байна. Нийт нэмэгдүүлж баталсан төсвийн 70.0 хувийг Засаг дарга ерөнхий дансны зардлыг, 10.0 хувийг аймгийн ЗДТГ-ын зардлыг санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

Хүснэгт 13. Аймгийн 2024 оны төсвийн тодотгол

| ҮЗҮҮЛЭЛТ   | ИТХ-ын<br>2023.12.01<br>№71<br>тогтоолоор<br>баталсан<br>төсөв | ЗДТГ-аас<br>тодотгол<br>хийхээр өргөн<br>барьсан | ИТХ-ын<br>2024.08.30<br>№39<br>тогтоолоор<br>баталсан төсөв | /сая төгрөг/<br>Нэмж баталсан төсөв |                 |                 |
|--|--|--|---|-------------------------------------|-----------------|-----------------|
|  |  |  |   | ЗДТГ-<br>аас                        | ИТХ-<br>аас     | Нийт дүн        |
| Татварын орлого  | 2,504.0  | 10,483.1   | 15,603.1  | +7,979.1                            | +5,120.0        | +13,099.1       |
| Татварын бус орлого                                      | 1,793.3  | 1,793.3  | 1,793.3   | -                                   | -               | 0.0             |
| УТ-ын дэмжлэг  | 33,672.0   | 26,064.8   | 26,064.8  | -7,607.2                            | -0              | -7,607.2        |
| ОНХС-гийн<br>шилжүүлэг                                   | 16,592.9   | 17,357.4   | 17,357.4  | +764.5                              | -               | +764.5          |
| Урьд оны үлдэгдлээс                                      | 431.3  | 431.3  | 991.3   | -                                   | +560.0          | +560.0          |
| ЕБ сумын төсвөөс<br>аймгийн төсөвт<br>төвлөрүүлэх орлого | 2,979.6  | 3,610.8  | 4,610.9   | +631.2                              | +1,000.1        | +1,631.3        |
| өөрийн орлогоос  | 627.0  | 627.0  | 627.0   | 0.0                                 | 0.0             | 0.0             |
| <b>НИЙТ ЭХ ҮҮСВЭР</b>                                    | <b>58,600.3</b>  | <b>60,367.9</b>                                  | <b>67,047.9</b>   | <b>+1,767.6</b>                     | <b>+6,680.0</b> | <b>+8,447.6</b> |
| Аймгийн ИТХ  | 1,078.1  | 1,078.1  | 1,253.1   | -                                   | +175.0          | +175.0          |
| Засаг дарга  | 18,514.3   | 19,701.0   | 25,429.9  | +1,186.7                            | +5,728.9        | +6,915.6        |
| Хөрөнгө оруулалт   | 2,328.4  | 2,363.4  | 2,533.8   | +35.0                               | +170.4          | +205.4          |
| Сумдад олгох<br>шилжүүлэг                                | 19,705.2   | 19,486.6   | 20,092.4  | -218.6                              | +605.8          | +387.2          |
| ОНХС-гийн<br>шилжүүлэг                                   | 16,974.2   | 17,738.7   | 17,738.7  | +764.5                              | 0.0             | +764.5          |
| <b>НИЙТ ЗАРДАЛ</b>                                       | <b>58,600.3</b>  | <b>60,367.9</b>                                  | <b>67,047.9</b>   | <b>+1,767.6</b>                     | <b>+6,680.0</b> | <b>+8,447.6</b> |

Эх сурвалж: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны тогтоол

Гэвч аймгийн татварын болон татварын бус орлого 7,312.5 сая төгрөгөөр тасарч, сумдад 2,620.8 сая төгрөг, аймгийн төсвийн байгууллагуудад 4,944.0 сая төгрөгийн нийт 7,564.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон.

Сум, байгууллага, дансад санхүүжилтийг харилцан адилгүй хуваарилсан байна.

Тухайлбал: Орон нутгийг судлах музейд баталсан санхүүжилтийн 46.7 хувийг, ОНТХО дансанд 51.0 хувийг, Жаргалан сумд 68.5 хувийг, Цээл сумд 74.8 хувийг, Бигэр суманд 77.5 хувийг, Тайшир сумд 97.0 хувийг, Чандмань сумд 95.5 хувийг, Цогт сумд 92.0, Хүнс хөдөө аж ахуйн газарт 96.2 хувийг, Санхүүгийн хяналт аудитын албанд 99.4 хувийг, Орон нутгийн өмчийн газарт 100.0 хувийг тус тус харилцан адилгүй хуваарилсан байна.

Дутуу санхүүжилт авсан сум, байгууллагууд 2,452.4 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан нь төлөвлөлтийг үндэслэлгүй хийсэн байна.

Төсвийн тодотголыг хийхдээ холбогдох хууль эрх зүйн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийг харгалзахгүйгээр үндэслэлгүй тооцон, аймгийн ИТХ-аас дахин нэмж баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2<sup>8</sup>, 56 дугаар 56.3.2<sup>9</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна. Иймд уг асуудлыг анхаарч үзэж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт уламжилсан.

Говь-Алтай Засаг дарга ерөнхий данснаас 57.8 сая төгрөгийн урсгал зардлыг аймгийн төсвийн 5 байгууллагад өр барагдуулахаар төсөвт зохицуулалт хийсэн байна.

### 5.2 Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт, хэрэгжилт

Төрийн аудитын байгууллага нь тооцоо, судалгаандаа үндэслэн 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 1,404.9 сая төгрөгийн, зардал бууруулах 1,445.1 сая төгрөгийн, үр ашгийг нэмэгдүүлэх 9 саналыг хүргүүлсэн.

Хүснэгт 14. Төсвийн төсөлд өгсөн санал, хэрэгжилт

/сая.төгрөг/

| Үзүүлэлт              | Төсвийн санал |                | Саналын хэрэгжилт |            |          |
|-----------------------|---------------|----------------|-------------------|------------|----------|
|                       | Тоо           | Мөнгөн дүн     | Тоо               | Мөнгөн дүн | Хувь     |
| Зардал бууруулах      | 3             | 1,445.1        | 0                 | 0          | 0        |
| Орлого нэмэх          | 11            | 1,404.9        | 0                 | 0          | 0        |
| Үр ашгийг нэмэгдүүлэх | 9             | 0.0            | 0                 | 0          | 0        |
| <b>Дүн</b>            | <b>23</b>     | <b>2,850.0</b> | <b>0</b>          | <b>0</b>   | <b>0</b> |

Эх сурвалж: 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын тайлан

Төсвийн төсөлд өгсөн саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй, биелэлтийг ирүүлээгүй байна.

Аймгийн 2024 оны төсвийн санхүүгийн нийт эх үүсвэр 95,867.2 сая төгрөг, нийт зарлага 76,355.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 3,327.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан

| Код | Үзүүлэлт                          | Төлөвлөгөө | Гүйцэтгэл        | Зөрүү /+хэмнэлт, -хэтрэлт/ | Хувь |
|-----|-----------------------------------|------------|------------------|----------------------------|------|
| I   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 95,867.2   | 76,355.0         | 19,512.1                   | 80   |
| II  | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР    | 95,867.2   | 79,682.3         | 16,184.8                   | 83   |
|     | <b>Төсвийн тэнцэл</b>             |            | <b>(3,327.3)</b> | <b>(3,327.3)</b>           |      |

8 Засаг дарга, хот, тосгоны Захирагч дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ

9 иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөл тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан;

### 5.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

нэгтгэсэн тайлангийн аудитаар 5,293.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлж, 7 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд хангалтгүй байна.

## VI. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 23,248.6 сая төгрөгийн 11 зөрчил<sup>10</sup> илэрснээс, 3,438.4 сая төгрөгийн 4 албан шаардлага, 17,710.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлж, 2,100.0 сая төгрөгийн 2 зөрчлийг шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторт, 3 саналыг Засгийн газрын нэгтгэсэн тайланд тусгуулахаар Үндэсний аудитын газарт уламжлав.

Аймгийн 2024 оны төсвийн санхүүгийн эх үүсвэрийн дүн 95,867.2 сая төгрөг, нийт зарлагын дүн 76,355.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.

Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг 40,664.1 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 15,987.7 сая төгрөгөөр, төсвийн төслөөс 29,096.8 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан суурь орлогоос 27,099.1 сая төгрөгөөр, анх баталсан төсвөөс 18,575.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.
2. Сангийн яамнаас хянаж ирүүлсэн ААНОАТ-ыг 12,799.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталж, гүйцэтгэлээр 8,522.5 сая төгрөгөөр тасарчээ.
3. Төлөвлөлтийг бодитой тооцоогүйгээс аймгийн орон нутгийн 4 нэр төрлийн татварын орлого 9,565.3 сая төгрөгөөр, түрээсийн орлого 18.0 сая төгрөгөөр, нийт 9,583.3 сая төгрөгөөр тасарсан.
4. Орон нутгийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс орлого тасарч, сумдад 2,620.7 сая төгрөг, аймгийн төсвийн байгууллагуудад 4,944.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос, тайлант онд өр төлбөр үүсэж, төсвийг зохистой удирдан зохион байгуулаагүй байна.
5. Нэмэлт төсвийн 4,054.1 сая төгрөгийн 47.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 29.6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд зарцуулсан байна.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ЗДТГ болон бусад төсвийн байгууллагуудын өөрийн орлого, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг зарим сумууд огт төлөвлөөгүй байна.
7. Төсвийн ангилал зөрчин зарим төсвийн байгууллагуудад 6.0 сая төгрөгийн хоолны зардлыг төлөвлөж, батлуулан, зарцуулсан байна.
8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 31.7 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон.
9. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 2,100.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна.
10. Засаг дарга ерөнхий дансны санхүүжилт өмнөх оноос 3.5 дахин нэмэгдэж 9,215.0 сая төгрөгийн эх үүсвэрийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр, сумдын ой

<sup>10</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тэмдэглэх, бусад хөтөлбөр арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулж, урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

11. Төсөвт тодотгол хийхдээ хууль тогтоомжид заасан шалгуурыг харгалзахгүйгээр нийт эх үүсвэр, зардлыг 8,447.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж батлан, Засаг дарга ерөнхий дансанд 80.0 хувийг хуваарилсан байна.

### **6.1 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ**

Дараах асуудлуудыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн аудитын тайланд тусгуулж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх саналыг уламжилж байна.

Үүнд:

1. Засаг дарга ерөнхий дансны санхүүжилт жилээс жилд нэмэгдэж, 2020 онд 380.5 сая төгрөг, 2021 онд 602.5 сая төгрөг, 2022 онд 1,169.5 сая төгрөг, 2023 онд 2,706.0 сая төгрөг байсан бол 2024 онд 3.5 дахин нэмэгдэж 9,215.0 сая төгрөг болжээ. Засаг дарга ерөнхий данснаас 2024 онд 3,438.4 сая төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт, сумдын ой тэмдэглэхэд 1,400.0 сая төгрөгийг, 1,942.6 сая төгрөгийг бусад хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсээр байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч, зөвлөхөд 62.5 сая төгрөгийн, Цогт сумын Засаг даргын орлогчид 24.8 сая төгрөгийн цалин олгосон байна.
3. Төсвийн тодотголоор аймгийн Засаг даргаас ААНОАТ-ыг 7,679.1 сая төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 631.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д өргөн барьсан бөгөөд аймгийн ИТХ-аас ААНОАТ-ыг 5,120.0 сая төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 1,000.0 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 560.0 сая төгрөг, нийт 14,990.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг үндэслэггүйгээр нэмж баталсан байна. Нэмсэн эх үүсвэрийг Засаг дарга ерөнхий дансанд 5,679.5 сая төгрөг, аймгийн ЗДТГ-т 1,089.0 төгрөг, аймгийн ИТХ-д 175.0 сая төгрөг, БОАЖГ-т 13.3 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилж, баталсан байна.

### **6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

#### **Аймгийн ИТХ-ын даргад:**

1. Орон нутгийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлага хангасан төсвийг хэлэлцэн баталж байх.
2. Хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлага үүссэн тохиолдолд төсвийн тодотголыг хэлэлцэн баталж байх.

#### **Аймгийн Засаг даргад:**

1. Баталсан төсвийг зохистой удирдан, харьяа байгууллагуудад хуваарийн дагуу санхүүжилтийг тухай бүр олгож, өр төлбөр үүсгэхгүй байх.
2. Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад журам зааварт нийцүүлэн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төсвийг боловсруулж, батлуулах.
3. Төсвийн байгууллагуудын өөрийн орлогыг бодитой төлөвлөж, батлуулах.
4. ЗДТГ, ИТХ-ын төсөвт хоолны зардлыг төлөвлөхгүй байх.

#### **Сумдын Засаг дарга нарт**

1. Төсвийн байгууллагуудын өөрийн орлогыг бодитой төлөвлөж, батлуулах.

#### **Тонхил, Халиун, Дарив, Эрдэнэ, Есөнбулаг сумдын Засаг дарга нарт**

1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг өөрийн орлогоор үндэслэлтэй төлөвлөж, батлуулах.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

20 25 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 02/208

Алтай хот

ТТН - 2025/001 - НН-СТН-ТЭЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн тодотголоор аймгийн Засаг даргаас ААНОАТ-ыг 7,679,100,00.00 (Долоон тэрбум зургаан зуун далан есөн сая нэг зуун мянга) төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 631,200,000.00 (Зургаан зуун гучин нэгэн сая хоёр зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д өргөн барьсан боловч бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим болон дараах зарчмуудыг удирдлага болгоно:; 7 дугаар зүйлийн 7.2-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тодотголыг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говь-Алтай аймгийн Засаг дарга (Г.Чинбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Д.ЦЭРЭНХАНД

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Хөгжил хороолол 1402 Утас 70484030

8225041802



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 03/208

А0760260

Алтай хот

ГАН - 2025/001 - НА - СТА - ТЕЗ  
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 31,901,700.00 (Гучин нэгэн сая есөн зуун нэг мянга долоон зуу) төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн

8217144139  
ДТ0А0060 0018301

8225041796

**ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын төсөвт учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говь-Алтай аймгийн Засаг дарга (Г.Чинбат), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Д.Даваадорж)-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Д.ЦЭРЭНХАНД

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Хөгжил хороолол 1402 Утас 70484030



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

А0760260

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 04/208

Алтай хот

ТНН-2025/001-НА-СТА-ТЭЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн Засаг дарга ерөнхий данс нэртэй 100050051000 тоот данснаас 3,438,451,600.00 (Гурван тэрбум дөрвөн зуун гучин найман мянга дөрвөн зуун тавин нэгэн мянга зургаан зуу) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт, сумдын ой тэмдэглэхэд 1,400,000,000.00 (Нэг тэрбум дөрвөн зуун сая) төгрөгийг, 1,942,611,400.00 (Нэг тэрбум есөн зуун дөчин хоёр сая зургаан зуун арван нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийг бусад хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.42-т "төсвийн ерөнхий данс" гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг", 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; Засгийн газрын "Журам шинэчлэн батлах тухай" 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан журмыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

- Ерөнхий данс нэртэй данснаас урсгал зардал болон бусад зардлыг санхүүжүүлж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говь-Алтай аймгийн Засаг дарга (Г.Чинбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ) -т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ  
Д.ЦЭРЭНХАНД

8217144139

ДЮА0000 0018301

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Хөгжил хороолол 1402-Утас 70484030

8225041799



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 05/208

А0760260

Алтай хот

ГАА - 2025/001/ - НА - СТА - ТЭЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 2,100,000,000.00 (Хоёр тэрбум нэг зуун сая) төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг хэлбэрээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар анхан шатны нотлох баримтгүйгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.6-т "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар зарцуулалт хийж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Чинбат), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Д.Даваадорж)-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Д.ЦЭРЭНХАНД



8225041817

<sup>1</sup> Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Хөгжил хороолол 1402 Утас 70484030